

AVSF МОНГОЛ БАЙГУУЛЛАГА

ХИЛ ХЯЗГААРГҮЙ МАЛЫН ЭМЧ НАР БА АГРОНОМИЧИД



Бүгд Найрамдах Франц улсад төвтэй “Хил хязгааргүй малын эмч нар ба агрономичид” буюу AVSF ТББ нь 1977 оноос хойш олон улсын эв санааны нэгдлийн төлөө өрхийн бичил аж ахуйг дэмжин ажилладаг.



Дэлхийн 20 улсад
300 ажилтантай

75
төсөл

75 төсөл
хэрэгжүүлдэг



80 түнш
байгууллагатай

Анх 2004 онд байгуулагдсан AVSF Монгол байгууллага нь тогтвортой хөгжлийн хэрэгжилтэнд хувь нэмэр оруулж, бэлчээрийн доройтлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх зорилгоор түүхий эдийн тогтвортой үйлдвэрлэл, нэмүү өртгийн сүлжээг сайжруулах, малчдын амьжиргааг дэмжих чиглэлд үйл ажиллагаа хэрэгжүүлдэг.

AVSF Монгол байгууллагын төслүүд түүхий эдийн нэмүү өртөг бий болгох, малчдын амьжиргааны эх үүсвэрийг төрөлжүүлж бэлчээрийн зохистой менежментийг хэрэгжүүлэх, тогтвортой ноос, ноолуурын үйлдвэрлэлийг малчдын хоршоодоос боловсруулах үйлдвэр, хэрэглэгч хүртэлх үе шат бүрт нэвтрүүлж, хөгжүүлэхэд техник, арга зүйн туслалцаа үзүүлж, ур чадвар эзэмшүүлэх зорилготой.

AVSF МОНГОЛ БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ЗАРЧМУУД



Малчдын бүлэг,
хоршоодтой
хамтран ажиллах



Малын удмын сан,
эрүүл мэндийг
сайжруулах



Түүхий эдийн
чанарыг эрхэмлэх



Байгаль орчныг
хамгаалахад хувь
нэмэр оруулах

AVSF МОНГОЛ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

AVSF Монгол байгууллага нь агуулга, арга барилын хувьд хоорондоо нягт уялдаа бүхий төслүүдийг дараах аймгуудад хэрэгжүүлдэг. Үүнд:



Баянхонгор
аймаг



Архангай
аймаг



Хэнтий
аймаг

Тогтвортой
ноолуур



Хүнсний
ногоо



Сарлагийн
хөөвөр



ТОГТВОРТОЙ НООЛУУР ХОЛБОО

Тогтвортой ноолуур Холбоо нь 2017 онд AVSF Монгол байгууллагын дэмжлэгтэйгээр тогтвортой ноолуур бэлтгэгч хоршоодын санаачилгаар байгуулагдсан ашгийн бус, гишүүдэд үйлчилдэг төрийн бус байгууллага юм. Өдгөө эгнээндээ Баянхонгор аймгийн таван хоршоодын 350 өрхийн 1600 гаруй малчдыг элсүүлж, гадаад, дотоодын 20 гаруй компанид нэмүү өртөг шингээсэн тогтвортой ноолуур нийлүүлж байна.

[@Sustainable Cashmere Union/Тогтвортой ноолуур холбоо](#)



"ТЕКСТИЛИЙН ТОГТВОРТОЙ ҮЙЛДВЭРЛЭЛ БА ЭКО ТЭМДЭГ" ТӨСӨЛ (STeP EcoLab)

Европын холбооны санхүүжилтээр хэрэгжиж буй STeP EcoLab буюу "Текстилийн тогтвортой үйлдвэрлэл ба эко тэмдэг" төсөл нь ноос, ноолуурын байгаль орчинд ээлтэй, тогтвортой үйлдвэрлэлийг боловсруулах үйлдвэрүүдийн төвшинд бий болгохыг зорино. Төсөл нь түнш байгууллагуудтайгаа хамтран дотоодын үйлдвэрүүд үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг баталгаажуулах Сайн дурын үйл ажиллагааны дүрмийг хэрэгжүүлж, ногоон зээлийн шалгууруудыг хангахад нь арга зүйн дэмжлэг үзүүлдэг юм. Ийнхүү тогтвортой байдлыг хангасан Монголын ноолуур, ноолууран бүтээгдэхүүнийг гадаад, дотоодын зах зээлд сурталчилж, Тогтвортой Хөгжлийн 12-р зорилтыг ноос, ноолуурын салбарт биелүүлэхэд бодит хувь нэмэр оруулахыг зорино.

[@STePEcoLab](#)



"ТОГТВОРТОЙ НООЛУУР" ГЭРЧИЛГЭЭ

Тогтвортой ноолуур Холбоо нь хоршоодын бэлтгэж буй түүхий эдийн нэмүү өртгийн үндэслэл болон чанарын баталгаа болох 25 шалгуур бүхий "Тогтвортой ноолуур" гэрчилгээжүүлэлтийн схемийг нэвтрүүлэн хэрэгжүүлдэг юм. "Тогтвортой ноолуур" гэрчилгээг аймаг, үндэсний хэмжээний Гэрчилгээжүүлэлтийн хороод хоршоодын үйл ажиллагааг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу хянаж үзсэний үндсэн дээр олгодог. Ингэснээр тухайн хоршоо нь ноолуурыг байгальд ээлтэй, малчдад хүртээмжтэй, эдийн засгийн хувьд алдагдалгүй аргаар буюу тогтвортой ноолуур бэлтгэн нийлүүлж байгааг баталгаажуулж байгаа юм.

AVSF Монгол байгууллагатай холбоо барих



"ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛД ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ ОРОЛЦООГ ХАНГАХ НЬ" БУЮУ ИМПАКТ ТӨСӨЛ

Европын холбооны санхүүжилтээр хэрэгжүүлж буй ИМПАКТ төслийн зорилго нь орон нутгийн түвшинд шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, чадваржуулах, тогтвортой ноолуур, органик ногоо, тариалангийн үйлдвэрлэлийг эмэгтэйчүүдийн манлайлал, оролцоотойгоор хөгжүүлэхэд оршино. Төслийг Архангай, Хэнтий аймгийн сумдад ЖЭРЭС ОУТББ болон Монголын эмэгтэйчүүдийн сантай хамтран хэрэгжүүлдэг бөгөөд эрчим хүчний хэмнэлттэй шийдлүүдийг нэвтрүүлж, тогтвортой ноолуур, органик ногоо тариалалтын сайн туршлагуудыг бий болгох замаар иргэний нийгмийн байгууллагууд болон үйлдвэрлэгч эмэгтэйчүүдийг чадваржуулж, шийдвэр гаргах үйл явцад оролцдог, орон нутгийнхаа эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулдаг болоход нь дэмжлэг үзүүлэх чиглэлд үйл ажиллагаа явуулдаг юм.

[@IMPACTMongolia](#)

САРЛАГИЙН ХӨӨВРӨН BABY YAK БРЕНД

AVSF Монгол байгууллага нь Архангай аймгийн малчдыг дэмжиж, чадавхижуулсаны үр дүнд Ар арвижин дэлгэрэх хоршоо байгуулагдаж, хоршооны гишүүд өдгөө AgriCoop тэмдэгт бүхий сарлагийн хөөврөн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, Baby Yak бренд нэрээр экспортолдог. Хоршооны гишүүд анх малын эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр сургалтуудад хамрагдаж, сарлагийн хөөвөр цуглуулах, бүтээгдэхүүн хийх зорилгоор нэгдэж өдгөө бие даан үйл ажиллагаагаа эрхэлж байна.

[@BabyYakCaad](#)



AVSF Монгол байгууллагын түнш байгууллагууд:

- ХХААХҮЯ
- БОАЖЯ
- Аймгийн ЗДТГ
- Сумдын удирдлага
- Монголын ноос ноолуурын холбоо
- Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо
- Тогтвортой санхүүжилт холбоо
- Тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээний хамтын ажиллагааны төв

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, МГГ байрны 4 давхар
Утас: +976-70110043